



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРЦАГА

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 23-06-25/95

Дархан

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 23-01-25-01/25 дугаар удирдамжийн дагуу Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023, 2024 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтаар "ТБ ГБ23:ОНХС04" дугаартай "Тариалангийн талбайд цахилгаан дамжуулах агаарын шугам татах" ажил, ГБ23:ОНХС08 дугаартай "Сумын хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг /шар дэрс/ хийх" ажил, ТБ ГБ23:ОНХС05 дугаартай "Худгийн автоматжуулалт хийх" ажил, ТБ ГБ24:ОНХС01 дугаартай "Өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл худалдан авах" төсөл арга хэмжээ, ТБ ГБ24:ОНХС02 дугаартай "Сумд экскаватор худалдан авах" төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн ба ажлын хэсэг нь гэрээг дүгнэхдээ гэрээнд заасны дагуу нийт 11,469.0 мянган төгрөгийн алданги тооцохгүйгээр хүлээж авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт "хариуцлагатай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11 дэх заалт "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх", Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, "Цац эрчис ХХК"-тай байгуулсан "ТБ ГБ23:ОНХС04" дугаартай гэрээний гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-ийн 4.17 дахь заалтад "Гэрээний үүргээ биелүүлээгүй хоног тутамд 0.5 хувиар алданги тооцно", Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, "Эм си ар эл ХХК"-тай байгуулсан ТБ ГБ23:ОНХС05 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-ийн 10.22 дахь заалтад "Гэрээний үүргээ биелүүлээгүй хоног тутамд 0.5 хувиар алданги тооцно", Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, "Монтех дистрибьюшн ХХК"-тай ТБ ГБ24:ОНХС01, ТБ ГБ24:ОНХС02 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-ийн 4.17 дахь заалтад "Гэрээний үүргээ биелүүлээгүй хоног тутамд 0.05 хувиар алданги тооцно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

457000222

Иймд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар **ШААРДАХ нь**:

1. Ажил, төсөл арга хэмжээний гэрээ дүгнэж, хүлээж авахдаа гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан алдангийг тооцон санхүүжилтийг өгөх, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтад "Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй" болохыг дурдсугай.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Л.ДАГИЙСҮРЭН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

А.ДӨЛГӨӨН

ДОТООД АУДИТОР

Н.ДЭЛГЭРМАА

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.ТҮМЭНЦОГТ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.МӨНХБАЯСГАЛАН

ЭДИЙН ЗАСАГЧ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Д.МИШЭЭЛТ